

СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/12

Баруун-Урт сум

Ажлын байрны дүгнэлт хийх
шинжээч томилох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.11, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл, Эрүүл мэнд, спортын сайдын 2021 оны 400 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МЭИК” ХХК Баруун-Урт дахь салбарын Эмийн сан-2-ын байршил өөрчлөгдөж байгаа тул шинээр орж байгаа байранд үйл ажиллагаа явуулах ажлын байранд тавигдах стандарт шаардлага, шалгуурын хангалтад хяналт шалгалт хийх шинжээчээр /Д.Барцэцэг/-ийг томилсугай.

2. Хяналт үнэлгээг 2022 оны 03 дугаар сарын 15-аас 5 хоногт багтаан хийж гарсан дүгнэлтийг илтгэх хуудсаар тусгай зөвшөөрөл олгох комисст танилцуулахыг шинжээчид үүрэг болгосугай.

3. Шинжээчийн зардал 50000, /тавин мянган/ төгрөгийг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орлогоос гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Ж.Оюунзул/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг комиссын нарийн бичгийн дарга /Ш.Жадамба/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



П.БОЛОРМАА

My doc mayagt tushaal